



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/195

Мандалговь


Үнэлгээний хороо байгуулах  
захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 45.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад Засаг даргын Тамгын газар захиалагч байна гэж хуульчлагдсаны дагуу 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Ууганбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн А/228 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190531